



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2019 оны 03 сарын 22 өдөр

Дугаар А/192

Ховд

Газар эзэмших эрх шилжүүлэх тухай

Монгол Улсын Газрын тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.1, 38.3, 38.4 дэх заалт аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2010 оны 12 дугаар сарын 24-ний өдрийн 267 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Жаргалант сумын Магсаржав багийн нутаг дэвсгэр Амарсанаагийн 1 дүгээр гудамж 105 а тоотод байрлах үйлчилгээний зориулалттай "Сэтэрхүрэн" /2352036/ 61.0 метр квадрат газрыг, газар эзэмших эрх шилжүүлэх гэрээний дагуу Ядмаагийн Базаррагчаад /ПИ81102136/ үйлчилгээний зориулалтаар 9 жилийн хугацаагаар,

2. Жаргалант сумын Магсаржав багийн нутаг дэвсгэр Баянгол 3 дугаар гудамжны 304 тоотод байрлах орон сууцны зориулалттай "Бүтээмж тауэр" ХХК-ний /4079949/ 1019.0 метр квадрат газраас, газар эзэмших эрх шилжүүлэх гэрээний дагуу 501 метр квадрат газрыг "Жаргалант ургамал" ХХК /4080246/-д орон сууцны зориулалтаар, үлдсэн 518 метр квадрат газрыг "Бүтээмж тауэр" ХХК-д /4079949/ Баянгол 3 дугаар гудамжны 304 б тоот болгон орон сууцны зориулалтаар 4 жилийн хугацаатайгаар тус тус шилжүүлсүгэй

3. Газар эзэмших эрхийг хуулийн дагуу шилжүүлж газраа зориулалтын дагуу үр ашигтай, зүй зохистой эзэмшиж, хамгаалж, газар эзэмшүүлэх гэрээнд заасан нөхцөл болзлыг биелүүлж ажиллахыг дээрх иргэн, аж ахуй нэгжид үүрэг болгосугай.

4. Газар эзэмших эрх нь баталгаажсан аж ахуйн нэгж, байгууллагатай газар эзэмшүүлэх гэрээ байгуулж, газар эзэмших эрхийн гэрчилгээ олгон, газрын төлбөрийг хууль тогтоомжийн дагуу төвлөрүүлэн гэрээний биелэлтэнд хяналт тавьж ажиллахыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар /Б.Баярсүх/-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

Б.ДҮГЭРЖАВ



Zax A/192 Ch
02 00896